



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/829

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.а, 29.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алагтолгой багт баригдсан Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын барилга барих газрын трасст орсон 1-17 тоот айлын газар чөлөөлөх, нөхөн олговор олгох зардал 40 000 000 төгрөг /дөчин сая/-ийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 40 000 000 төгрөг /дөчин сая/-ийг аймгийн Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 4.2 "Авто замын трасст орсон айлын газар чөлөөлөлтийн зардал /Жаргалант сум/-аас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ